21.1. ЭЕШ давтлага хичээл бүртгэх

21.1. ЭЕШ давтлага хичээл бүртгэх

ЭЕШ-д бэлтгэх давтлага хичээлийн бүртгэлийг системд хийхдээ дараах дараалалыг баримтлана. Үүнд:

1. Давтлага хичээл орох багшийн заадаг хичээлд давтлага хичээлийг үүсгэж өгөх
2. “Хичээлийн бүлэг”-ээр ээлжит хичээл үүсгэж баталгаажуулах
3. Хичээл сонголтоор суралцагчийг сонгож бүртгэнэ.
4. Ирц бүртгэнэ.

Системд хэрхэн оруулах алхамчилсан дараалал:

1. Багшийн заадаг хичээл оруулах

Сургалтын менежер **Боловсролын удирдлагын систем**ийн **Багш** үйл ажиллагаа руу орж багшийн нэрийн жагсаалтаас тухайн багшийг сонгож нэр дээр дарж орсноор багшийн мэдээллийн дараах цонх руу шилжинэ.



Баруун дээд хэсэгт байрлах **мэдээлэл засах** товчийг дарж орно. **+Хичээл нэмэх** товчийг дарснаар заадаг хичээлийг оруулах мөр гарч ирнэ. ЭЕШ давтлага хичээлийн судлагдахуун, хичээлийг сонгож хадгална. Дараах хүснэгтээс сонгох судлагдахуун, хичээлийг харж зөв сонгоно уу.&lt

21.2 ЭЕШ давтлагын ирцийн нэгтгэл

ЭЕШ -ийн хичээлийн давтлагын ирцийн нэгтгэл

ЭЕШ -ийн хичээлийн давтлагын ирцийн нэгтгэлийг сургуулийн хэмжээнд "Статистикийн удирдлага" -ын "Ирцийн нэгтгэл" модулийг ашиглан хянах боломжтой.



Ирцийн нэгтгэл модульд ЭЕШ -ийн давтлагын ирцийг Огноо(1), Хичээл(1), Багшаар(1) шүүж харах боломжтой. Мөн нэгтгэлийг excel форматтай файл хэлбэрээр татаж(4) авч болно.